

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БАЯН-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

Нэг. ХУВЬ ХҮНИИ ХӨГЖИЛ

Салбарын зорилго: нийгмийн суурь үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар иргэдийн амжиргааг дэмжин гэр бүлд ээлтэй бодлого хэрэгжүүлнэ.

1.1. ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛ.

Зорилт 1. Боловсролын салбарын сурч боловсрох, хөгжих орчныг сайжруулж, сургалтын чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- 1.1.1. Хүүхэд бүрийг хөгжүүлж, бүтээлч сэтгэлгээтэй, өөртөө итгэлтэй, эх нутгийнхаа байгаль, түүх, үндэсний хэл соёл, уламжлалаар бахархдаг хүмүүжил олгох “Зөв Монгол хүүхэд” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.1.2. Элсэлтийн ерөнхий шалгалтанд 800 оноо авсан хүүхдийг Засаг даргын нөөцөөс урамшуулдаг болно.
- 1.1.3. Хүүхэд гэр бүл, цэцэрлэг, сургуулийн орчинд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, орчны эрүүл мэндийг сайжруулах бодлогыг нийгмийн эрүүл мэндийн үндсэн чиглэл болгоно.
- 1.1.4. Амжилттай хэрэгжиж буи “Мянган инженер” хөтөлбөрт орон нутгийн залуучуудыг хамруулж мэргэжилтэй ажиллах хүчний нөөцийг сайжруулах.
- 1.1.5. Сургууль, цэцэрлэгийн удирдлагыг мэргэшсэн, тогтвортой, улс төрөөс хараат бус баих нөхцөлийг бүрдүүлж, удирдах албан тушаалтныг чөлөөлөх, томилох асуудалд сумын иргэдийн төлөөллөөс бүрдсэн “Боловсролын зөвлөл”-ийн саналыг харгалздаг болгоно.
- 1.1.6. Ерөнхий боловсролын сургуулийн дээврийг шинэчилж, шувуун нуруутай болгоно.
- 1.1.7. Сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургуулийг шаардлагатай кабинет, цахим тоног төхөөрөмжөөр хангана.
- 1.1.8. Боловсролын байгууллагуудын хичээлийн болон дотуур байруудад орчин үеийн стандартад нийцсэн дуу, дүрс бичдэг хяналтын камерын тоог нэмэгдүүлнэ.
- 1.1.9. Хүүхдийн цэцэрлэгт хэрэглээний усны гүн өрмийн цооног гаргах.
- 1.1.10. 100-н хүүхдийн дотуур байрыг их засварт оруулах
- 1.1.11. Дотуур байр, бага сургуулийг боловсон 00, ширшүүртэй болгох
- 1.1.12. Бага сургуулийн гадна пасад засвар хийх
- 1.1.13. 320-450 хүүхдийн хичээлийн байр шинээр бариулах /номын сан урлаг заалтай байх/
- 1.1.14. Микро автобустай болох
- 1.1.15. Аймаг бүсийн спорт, урлаг соёлын тэмцээн бусад уралдаан тэмцээн олимпиадыг суманд зохион байгуулах
- 1.1.16. Багш нарын ур чадвар мэдлэг боловсролыг дээшлүүлэх сургалтанд хамруулах гадаад дотоодод туршлага дээшлүүлэх багш нарын сайн туршилгыг аймаг, бүсэд түгээн дэлгэрүүлэх, багшийн ёс зүй харилцаа хандлага, эрүүл мэнд , орон байрны нөхцөлийг сайжруулах.
- 1.1.17. Хөгжлийн бэрхшээлтэй болон эмзэг бүлгийн хүүхдүүд рүү чиглэсэн сургалт хүмүүжлийн ажлыг сумын хамтарсан багтай зохион байгуулах / сурах орчин нөхцөлийг бүрдүүлэх/
- 1.1.18. Хүүхдийн хүсэл сонирхол авьяас чадварт тулгуурласан секц дугуйлан хичээллүүлэх авьяас чадварыг нь нээх, хөрөнгө оруулалт хийх

- 1.1.19. Хүүхэд хөгжлийн танхимыг тохижуулах тоног төхөөрөмж тоглоом наадгай номоор хангах / 40,80,100-н хүүхдийн дотуур байр сургуулийн хүүхэд хөгжлийн танхим/
- 1.1.20. Хүнсний ногоо тариалах хүлэмжтэй болгох
- 1.1.21. Хүүхдийн чуулган зохион байгуулах /сумын ЗДТГ, сумын хамтарсан баг, төрийн байгууллага, төрийн бус байгуулагатай хамтарч/
- 1.1.22. Эцэг эх асран хамгаалагчын анхдугаар зөвлөгөөн зохион байгуулах /сумын ЗДТГ хамтарч төрийн ба төрийн бус байгуулагатай хамтарч/
- 1.1.23. Дотуур байрын хатуу эдлэлийг үе шаттай шинэчлэх /ор, ширээ сандал, шкаф г/м/
- 1.1.24. Насан туршийн боловсролын байрыг тохижуулах техник хэрэгсэлээр хангах
- 1.1.25. Биеийн тамир спортын талбайг тохижуулах
- 1.1.26. Төрийн болон төрийн бус байгууллага, хүүхдийн өөрөө удирдах байгууллагын хамтын ажиллагааг холбох , сайжруулах эцэг эх, сурагчдын дунд сургалт хүмүүжлийн ажил үе шаттай зохион байгуулах аян өрнүүлэх.

1.2. ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Зорилт 2. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлэн шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэлээр хангаж эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- 1.2.1. Иргэдийн халдварт болон халдварт бус өвчлөл, эх болон няраин эндэгдлийг бууруулж, урьдчилан сэргийлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.
- 1.2.2. Баян-өндөр сумын эрүүл мэндийн төвийн стандартыг хангуулж, шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэлээр хангана.
- 1.2.3. Хүнийг өвдөхөөс нь өмнө урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоог өрх гэрийн түвшинд тогтмол хийдэг эрүүл мэндийн үйлчилгээний шинэ хэлбэрийг бий болгож, гэрийн эмчийн шинэ тогтолцоонд шилжүүлнэ.
- 1.2.4. Иргэн бүрийг насны бүлэгт нь тохирсон урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулна.
- 1.2.5. Багийн эмч нарын мэргэжил, боловсролыг тасралтгүй дээшлүүлэхэд орон нутгийн төсвөөс дэмжлэг үзүүлнэ
- 1.2.6. Тэтгэвэр тогтоолгосон ахмад эмч нарыг эрүүл мэндийн төвд зөвлөхөөр ажиллуулахыг бодлогоор дэмжинэ.
- 1.2.7. Уламжлалт анагаах ухааны төвтэй болох ажлыг судалж хэрэгжүүлэх ажлыг эхлүүлнэ.
- 1.2.8. Баг бүрд улирал тутамд эрүүл мэндийн явуулын үзлэг оношилгоо хийж, сургалт зохион байгуулна.
- 1.2.9. Эрүүл мэндийн төвийг их засварт оруулна. Мөн гадна, дотор сантехникийг бүрэн шинэчлэнэ.
- 1.2.10. 5 дугаар багийг хүний эмчтэй болгох ажлыг зохион байгуулна.

1.3. ХҮН АМ, ӨРХ ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ

Зорилт 3. Хүн амын болон өрх, гэр бүлд ээлтэй хөгжил, хамгаалалын бодлого хэрэгжүүлэн гэр бүлийн хөгжлийг дэмжинэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- 1.3.1. Хүүхэд, залуучуудын хөгжлийн төв байгуулна.
- 1.3.2. Гэр бүлийн гишүүн бүрд гэр бүлийн боловсрол олгох, ажил хөдөлмөр эрхлэх, санхүү, бизнесээ хөгжүүлэх, амьдрах орчноо хамтдаа сайжруулах, мэдлэг ур чадварын сургалт, зөвлөмжөөр хангагдах боломжийг орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ.
- 1.3.3. Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэж, дарамт, мөлжлөгийн бүх хэлбэрээс хамгаалах хуулийн хэрэгжилтийг сайжруулна.
- 1.3.4. Хүүхдийг цахим мэдээллийн халдлагаас хамгаалах, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.
- 1.3.5. Иргэдэд зориулсан цахим боловсролын төвийн Насан туршийн боловсролын нэгжийг түшиглэн байгуулна.
- 1.3.6. Хүүхэд харах үйлчилгээг бий болгох замаар эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
- 1.3.7. Ахмадын хөгжлийн төвийг тогтмол үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлнэ.

1.4. НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Зорилт 4. Иргэдийн аятай тухтай нөхцөлд ажиллаж, амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлж хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- 1.4.1. Сумын нийгэм, эдийн засгийн бодлогод тулгуурлан шинээр бий болох ажлын байрыг төлөвлөн, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөр, хөнгөлөлтэй зээлд хамруулах замаар ажлын байрыг шинээр бий болгоно.
- 1.4.2. Ахмадын өдөр өнжүүлэх төвийг өргөжүүлж, байнгын ажиллагаатай болгоно. .
- 1.4.3. Малчдын нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлж, тэдний нийгмийн баталгааг хангана.
- 1.4.4. Зорилтот бүлгийн өрхүүдийн дунд бүлэг, хоршоо, байгуулан, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээгээр дэмжиж ажиллана.
- 1.4.5. Эх хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 1.4.6. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийг сайжруулахад чиглэсэн бодлого хэрэгжүүлнэ.

1.5. СОЁЛ, УРЛАГ,

Зорилт 5. Соёл, урлагийн салбарыг мэргэжлийн хүний нөөцөөр хангаж соёлын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэн үйл ажиллагааг сайжруулна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- 1.5.1 Уламжлалт өв соёл, монгол ахуйгаа өвлүүлэн үлдээх ажлыг бодлогоор дэмжинэ.
- 1.5.2 Соёлын биет ба биет бус өвийг хадгалан хамгаалах, сэргээн засварлах, түүнийг хамгаалан цуглуулагч, тээн уламжлагч нарыг сурталчлан дэмжиж, үндэсний агуулгатай үнэ цэнтэй өвийг хөгжүүлнэ.
- 1.5.3 Түүх соёлын дурсгалт газрын хамгаалалтыг сайжруулж, соёлын өвийг хамгаалагч, харгалзагч нарын урамшууллыг нэмэгдүүлнэ.
- 1.5.4 Орон нутаг судлах танхимийн үйл ажиллагааг сайжруулж соёлын өв хариуцсан ажилтантай болгоно.
- 1.5.5 Соёлын төвийг засварлан өргөтгөж, техник хэрэгсэлийг нэмэгдүүлнэ.
- 1.5.6 Соёлын төвийн үйлчилгээг сайжруулж хөдөөгийн багт бүрт урлаг соёлын үйлчилгээг хүргэх нөхцөл боломжоор хангаж, техник хэрэгсэлийг шинэчлэн, орчин үеийн техник хэрэгсэлээр бүрэн хангана.
- 1.5.7 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг соёлын үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулах, тэдний авъяас, хөдөлмөр бүтээлийг дэмжиж ажиллана.
- 1.5.8 Соёлын төвийн үйл ажиллагааг сайжруулахын тулд дутагдалтай боловсон хүчнээр хангана.
- 1.5.9 Сумын номын сангийн орчин нөхцөлийг сайжруулж үйл ажиллагааг жигдрүүлнэ.

1.6. БИЕИЙН ТАМИР

Зорилт 6. Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд спортыг дэмжиж, тамирчдын өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлэх, нийтийн биеийн тамирыг хөгжүүлнэ.

- 1.6.1. Спортын улс, бүсийн хэмжээний уралдаан, тэмцээнийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ, улс бүс, олон улсын тэмцээнд оролцох баг тамирчдын зардалд орон нутгийн зүгээс дэмжлэг үзүүлдэг тогтолцоог бий болгоно.
- 1.6.2. багуудын дунд Миний нутаг сайхан спортын наадмыг 2 жил тутамд зохион байгуулна.
- 1.6.3 нийтийн биеийн тамирын арга зүйчтэй болж нийтийн биеийн тамирыг хөгжүүлнэ.
- 1.6.4. Шагайн харваа, үндэсний бөх, гар бөмбөгийн сумын аварга шалгаруулах тэмцээнүүдийг жил бүр зохион байгуулна.

Хоёр. ХҮРТЭЭМЖТЭИ ЭДИЙН ЗАСАГ

Салбарын зорилго: Хөдөө аж ахуй, жижиг дунд бизнесийн салбарыг хөгжүүлэн өрсөлдөх чадвартай сум болно.

2.1. ЖИЖИГ ДУНД БИЗНЕС ЭРХЛЭЛТ

Зорилт 1. Жижиг дунд, үйлдвэрлэлийг дэмжих замаар жил багагүй өрхийн орлогыг нэмэгдүүлнэ

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- 2.1.1 Сум хөгжүүлэх сангийн зээлийг иргэдэд тэгш хүртээмжтэй, ялгаварлалгүйгээр олгоно.
- 2.1.2 Сум хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг жил бүр тогтвортойгоор нэмэгдүүлэн, нутгийн Брэнд бүтээгдэхүүн бий болгоход бодлогоор дэмжинэ.
- 2.1.3 Ажиллах хүчийг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах, ажлын байр олноор бий болгохыг нэн тэргүүний зорилт гэж үзэн шинэ ажлын байрыг бий болгох бүтээн байгуулалт, бизнесийн төслүүдийг бүх талаар дэмжиж хөгжүүлнэ.
- 2.1.4 Төрийн албанаас бизнесийн салбарт шилжсэн баялаг бүтээгч иргэдийнхээ бизнес эрхлэлтийн, хөрөнгө оруулалтын анхны санхүүжилтийг бодлогоор дэмжинэ.
- 2.1.5 Төрийн албанаас эрт тэтгэвэртээ гарч жижиг дунд, бичил бизнесийн салбарт шилжин баялаг бүтээх иргэдээ эдийн засгийн бодлогоор дэмжинэ.
- 2.1.6 Эрдэс баялгийн, малын гаралтай түүхий эдийг боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэн ажлын байрыг бий болгохыг дэмжинэ.
- 2.1.7 Төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаанд орон нутгийн аж ахуйн нэгж болон хувийн хэвшлийг давуу эрхтэй оролцуулахыг дэмжиж ажиллана.
- 2.1.8 Орон нутгийн аж ахуй нэгж, компаниудын чадавх, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх төслүүдийг дэмжинэ. Мал аж ахуй, газар тариаланд суурилсан орон нутгийн онцлог шинэ брэнд бүтээгдэхүүний бизнес загвар хөгжүүлэхийг дэмжинэ.
- 2.1.9 Нутгийн брэнд “Айраг” бий болгох санал санаачилгыг дэмжинэ.

2.2. ДЭД БҮТЭЦ

Зорилт 2. Иргэдийн амьдрах орчин дахь нийтийн эзэмшлийн талбайн орчин нөхцөлийг сайжруулна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- 2.2.1 Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлаж, түүний дагуу шинэ суурьшлын төлөвлөлтөнд эрчим хүч, цэвэр бохирын инженерийн шугам сүлжээг бий болгох ажлыг эхлүүлнэ.
- 2.2.2 Үүрэн телефоны бүх сүлжээний өргөтгөл, хүртээмжийг нэмэгдүүлж 3, 4-р багт үүрэн холбооны сүлжээг оруулна.
- 2.2.3 Стандартад нийцсэн камерын системтэй болгоно.
- 2.2.4 Сумын төвийн хороолол гудамжийг цэгцэлж, жишиг гудамжууд бий болгоно.
- 2.2.5 Сумын төвийн гэрэлтүүлэгийг нэмэгдүүлж, шинэчлэл хийнэ.
- 2.2.6 “А” зэрэглэлийн бүсэд дахин төлөвлөлтийг хийнэ.
- 2.2.7 Сумын төвийн эвдэрсэн зам, талбайг засварлаж, үерийн ус орохоос сэргийлнэ.

2.3. ХҮНС ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭ

Зорилт 3. Гол нэр төрлийн чанартай хүнсээр иргэдийг хангах, гадагш борлуулдаг хүнсний бүтээгдэхүүний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- 2.3.1 Хүн амын гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний дотоод хэрэгцээг чанартай хүнсээр хүртээмжтэй хангаж, дотоод зах зээл дэх хүнсний нийлүүлэлтийн сүлжээнд аюулгүй байдлын тогтолцоог нэвтрүүлнэ.
- 2.3.2 Жимс, жимсгэний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, хэрэгцээг дотооддоо хангахад чиглэгдсэн хувийн хэвшлийн санаачилгыг дэмжин хэрэгжүүлнэ.
- 2.3.3 Орон нутгийн иргэдийн хүнсний хэрэгцээгээ өөрөө хангах, хүлэмжийн аж ахуй эрхлэх санаачилгыг бүх талаар дэмжинэ
- 2.3.4 Төмс, хүнсний ногооны болон мах хөлдөөх агуулах зоорь барих ажлыг эхлүүлнэ.
- 2.3.5 Зориулалтын дагуу айраг нөөцлөх стандартын савтай болж нутгийн брэнд Айраг бий болгохоор ажиллаж буй иргэдийг дэмжинэ.

Гурав. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

Салбарын зорилго:

3.1. ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ, ШИНЭ ХӨДӨӨ” ХӨТӨЛБӨР

Зорилт 1. Эдийн засаг, нийгмийн ач холбогдолтой төсөл төсөл, хөтөлбөрүүдийг дэмжиж иргэдийн амьдрах орчныг сайжруулна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- 3.1.1 Бэлчээрийн менежментийг сайжруулна.
- 3.1.2 Бэлчээрийн болон хүн амын усан хангамжийг сайжруулна
- 3.1.3 Хог хаягдлын менежментийг сайжруулна.
- 3.1.4 “Шинэ багийн төв”-төсөл хэрэгжүүлнэ.
- 3.1.5 Жижиг дунд үйлдвэрлэлийг бүх талаар дэмжинэ.
- 3.1.6 Суманд олгогдсон хайгуулын болон ашиглалтын лизензийг цуцлуулах ажилд анхаарч ажиллана.
- 3.1.7 Баян-Өндөрт үйлдвэрлэв худалдааны төв байгуулах
- 3.1.8 Төсөвт байгууллагуудын худалдан авалтад суманд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс худалдан авах
- 3.1.9 Жижиг дунд үйлдвэр эрхлэгчдэд сав баглаа боодлын дэмжлэг үзүүлэх, борлуулалтад анхаарах

3.2. “ЧИНЭЭЛЭГ МАЛЧИН” ХӨТӨЛБӨР

Зорилт 2. Мал аж ахуйн үйлдвэрлэлийг тооноос чанарт бодлого баримталж хөдөө аж ахуйн тогтвортой хөгжлийг хангана.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- 3.2.1. Мал аж ахуйн салбарыг эдийн засгийн үр ашигтай, орчин үеийн шинэ технологи, инновацад суурилж, хөгжүүлэн мэдлэг бүхий малчдыг малчин бизнесмен болгох замаар тогтвортой орлого бүхий хүчтэй дундаж давхаргыг тэлэх бодлого хэрэгжүүлнэ.
- 3.2.2. Иргэдийн санаачилгад суурилсан “Чинээлэг малчин” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 3.2.3. Малчдын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор сүү цагаан идээ үйлдвэрлэж буй иргэдийг олон нийтэд суртачилан таниулж, үзэсгэлэн худалдаанд тогтмол хамруулна.
- 3.2.4. Стандартын шаардлага хангасан “Мал няталгааны цэг” байгуулах иргэн, аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжинэ.
- 3.2.5. Цөм сүргийн болон хээлтүүлэгч малыг ялган тэмдэглэж бүртгэлжүүлэн, малыг нэгдсэн системд бүртгэх, малын ээмэг, чип худалдан авах ажлыг зохион байгуулна.
- 3.2.6. Мал сүргийн чанарыг сайжруулах, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх, сайжруулагч, хээлтэгч, хээлтүүлэгч мал худалдан авах, мал үржлийн ажлын багаж тоног төхөөрөмж худалдан авах
- 3.2.7. Чанартай малтай малчдыг урамшуулах тогтолцоог бий болгоно.
- 3.2.8. Малчдын хөдөлмөрийг хөнгөвчлөх чиглэлээр тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн үйлдвэрлэл, худалдаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжийг дэмжинэ.
- 3.2.9. Мал эмнэлгийн үйлчилгээний чанарыг сайжруулах, мал сүргийг халдварт болон гоц халдварт өвчингүй тайван бүс болгох.
- 3.2.10. Мал амьтны гаралтай халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх эрүүлжүүлэх, мал эмнэлгийн үйлчилгээний чанарыг сайжруулах замаар мал, амьтны гоц халдварт өвчингүй тайван бүс болгох.
- 3.2.11. Мал амьтны өвчний гаралт, тархалтыг бууруулж халдварт өвчнөөр тайван байдлыг баталгаажуулах зэрэг зорилтуудын хүрээнд сум орон нутагт нэн шаардлагатай байгаа халдваргүйтгэл хийх уураар халдваргүйжүүлэгч, дук машинтай болох
- 3.2.12. Мах сүүнд шинжилгээ хийж баталгаа гаргах лабораторийн багаж зэргийг сумын дөрвөн жилийн үндсэн чиглэлд тусгаж өгнө үү

3.3. БЭЛЧЭЭР АШИГЛАЛТ

Зорилт 3. Бэлчээр ашиглалтыг нэмэгдүүлэн доройтолоос сэргийлэх

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- 3.3.1 Малчдын хамтын оролцоонд тулгуурлан бэлчээр нутгийн тогтвортой ашиглалтыг хангаж, доройтсон бэлчээрийг сэргээх арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлнэ.

- 3.3.2 Бэлчээр хамгаалах зорилгоор мэрэгч болон байгаль орчинд сөрөг нөлөө ихтэй хортон шавьж устгах ажлыг зохион байгуулж хийнэ.
- 3.3.3 Оторт явсан малчдын асуудлыг сум хоорондын түвшинд шийдэж, өвөлжилт, хаваржилтын асуудлаар цогц арга хэмжээ авна.
- 3.3.4 Бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлж ногоон тэжээл тариалах иргэн, аж ахуйн нэгжийг дэмжинэ.
- 3.3.5 Бэлчээрийн олон наст ургамал тариалах иргэдийг дэмжиж ажиллана.
- 3.3.6 Бэлчээрийн даацыг харгалзан, гүний болон гар худгуудыг шинээр гаргана.
- 3.3.7 Булаг шандны эхийг хаших моджуулах ажлыг эхлүүлнэ.
- 3.3.8 Бэлчээрийн доройтолд орсон газрыг нөхөн сэргээх ажлыг эхлүүлнэ.
- 3.3.9 Бэлчээрт тариалах олон наст тэжээлийн ургамалыг туршиж эхлэнэ.

3.4. МАЛ АЖ АХУИ

Зорилт 4. Малын тоо толгойг зохистой түвшинд барьж тооноос чанарт шилжүүлэн мал аж ахуйг хөгжүүлж хөдөө аж ахуйн тогтвортой байдлыг хангана.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- 3.4.1. Малыг чанар, үүлдэр, угсааг сайжруулж эдийн засгийн ашигтай технологид суурилсан мал аж ахуйг бодлогоор дэмжинэ.
- 3.4.2. Махыг зах зээлд нэвтрүүлэх хяналтын горимыг сайжруулж, малыг вакцин, туулгад бүрэн хамруулан эрүүлжүүлэх ухаалаг хяналтын системийг нэвтрүүлнэ.
- 3.4.3. Хөдөөгийн малчин өрхийг дэмжин “Малжуулах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлнэ.
- 3.4.4. Малын үүлдэр угсааг сайжруулах тал дээр анхаарч ажиллана.
- 3.4.5. Баг тус бүрийг малын эмчтэй болгож, мал эмнэлгийн чанар хүртээмжийг сайжруулна.
- 3.4.6. Баг бүрд мал угаалгын ваннтай болж празит өвчнөөс урьдчилан сэргийлнэ.
- 3.4.7. Суманд нэгдсэн өвсний Фонд байгуулж, өвс тэжээлийн нөөц бүрдүүлнэ.
- 3.4.8. Сумын өвс тэжээлийн аюулгүйн нөөцийг сумаасаа бүрдүүлэх зорилгоор төр хувийн хэвшлийн оролцоотой аж ахуйн нэгж байгуулан, түүнийг газар, талбай, зарим шаардлагатай тоног төхөөрөмжөөр ханган үр ажигтай ажиллуулна.
- 3.4.9. Малын тоо толгойн албан татварын хуулийн дагуу татварын хувь хэмжээг тогтоохдоо малын тоо толгойноос чанарт шилжүүлэх бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ.
- 3.4.10. Бэлчээр ашиглалтыг сайжруулах журам гарган бэлчээрийн усжуулах, сэлгэж өнжөөх, хортон мэрэгчээс хамгаалах ажлуудыг хийж бэлчээрийн ашиглалтыг сайжруулна.
- 3.4.11. Малын гаралтай түүхий эдэд түшиглэсэн боловсруулах цех байгуулах санал санаачилгыг дэмжинэ.
- 3.4.12. Малын тэжээл боловсруулах цех байгуулах ажлыг бодлогоор дэмжинэ.
- 3.4.13. Хөв цөөрөм байгуулах боломж, нөхцөлийг судлана.

3.5. ГАЗАР ТАРИАЛАН

Зорилт 5. Газар тариалан явуулах боломжтой атаршсан талбайн ажиглалтыг нэмэгдүүлэх.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- 3.5.1 Малыг тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, бодлогоор дэмжинэ.
- 3.5.2 Орон нутгийн онцлогт тохирсон газар тариалангийн бодлогын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- 3.5.3 Цөлжилттэй тэмцэх зорилгоор, мод тарих ажлыг эхлүүлнэ.
- 3.5.4 Өрхийн үйлдвэрлэлээ нэмэгдүүлэх зорилгоор газар тариалан, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, тариалах иргэдийг бодлогоор дэмжинэ.

3.6. ИРГЭНДЭЭ ҮЙЛЧИЛДЭГ ЗАСАГЛАЛ

Зорилт 6. Иргэдийн төрийн үйлчилгээ авах боломж нөхцөлийг сайжруулж хөнгөн, шуурхай нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- 3.6.1. Нас, хүйс, хөгжлийн ялгаа, гэх мэт аливаа төрлийн ялгаварлал, дарамт, хүчирхийллийг ажлын байр, олон нийтийн бүх орчинд таслан зогсооход чиглэсэн үе шаттай арга хэмжээг тогтмол хэрэгжүүлнэ.

- 3.6.2. Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэхгэр бүл, сургуулийн орчинд хүүхдийн эрхийг хангахажлыг эрчимжүүлнэ.
- 3.6.3. Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас өөрийн биеэр ирж уулзах боломжгүй иргэд төрийн захиргааны албан тушаалтан, албан хаагчидтай онлайнаар уулзах боломжийг бүрдүүлнэ.
- 3.6.4. Төрийн байгууллагаас гаргах шийдвэрт ард иргэд, төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлж, төрийн үйлчилгээний шийдвэрийг шилэн болгож ажиллана.
- 3.6.5. Хууль сурталчлах, таниулах ажлын чанарыг дээшлүүлж, олон нийтэд хууль зүйн мэдээллийг шуурхай, үр дүнтэй хүргэж ажиллана.
- 3.6.6. Төсвийн зарцуулалт, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд тавих иргэний болон хөндлөнгийн хяналтыг нэмэгдүүлнэ.
- 3.6.7. Иргэд, аж ахуйн нэгжийн төрөөс авах үйлчилгээг бүрэн цахим хэлбэрт шилжүүлнэ.
- 3.6.8. Төрөөс зохион байгуулах аливаа төсөл, тендерийн сонгон шалгаруулалтыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, олон нийтэд ил тод нээлттэй болгоно.
- 3.6.9. Олон нийтийн цагдаатай болно
- 3.6.10. Цагдаагийн алба хаагч нарын ажиллах нөхцөлийг сайжруулж нөтбүүк, 3-н үйлдэлт принтер, мотоциклиор хангана.
- 3.6.11. Төрийн болон орон нутгийн өмчийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэлийн ашиглалт хамгаалалтыг сайжруулна.
- 3.6.12. Цаг уурын өртөөг шаардлагатай техник хэрэгсэлээр хангана.
- 3.6.13. Сумын байгуулагдсаны 100 жилийн ойг угтан шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.
- 3.6.14. Төрийн үйлчилгээг иргэдэд хөнгөн шуурхай хүргэх зорилгоор багийн Засаг дарга нарыг унаажуулах ажлыг хэрэгжүүлнэ.

Дөрөв. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Салбарын зорилго:

4.1. ХҮРЭЭЛЭН БУИ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ ЭКОСИСТЕМИЙН ТЭНЦВЭРТЭИ БАИДАЛ

Зорилт 1. Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг сайжруулна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- 4.1.1 Хог хаягдлын менежментийг сайжруулж иргэн аж ахуйн нэгж байгууллагын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх замаар хог хаягдалыг бууруулж хогийн цэгийг цэгцлэх ажлыг эхлүүлнэ.
- 4.1.2 Орчноо ногооруулсан иргэд, аж ахуйн нэгжийг урамшуулна
- 4.1.3 Иргэд, орон нутаг, олон нийттэй хамтран ногоон хөгжлийн бодлого хэрэгжүүлж, байгаль орчныг нөхөн сэргээнэ.
- 4.1.4 Усны нөөцийг нэмэгдүүлэх, нөхөн сэргээх зорилгоор булаг, шандны эхийг хашиж, хамгаалах
- 4.1.5 Усан орчны эрүүл ахуйг талаар сурталчилах
- 4.1.6 Гүн өрмийн худагт смарт төхөөрөмж тавих
- 4.1.7 Навчийн халуун ус, Бэлгэхийн халуун усны физик, химийн найрлагыг тогтоолгох
- 4.1.8 Байгаль орчны хууль тогтоомж, ногоон хөгжлийн боловсролыг олон нийтэд сурталчилан таниулж, байгаль хамгаалалд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх.

